

## ТАНИЛЦУУЛГА

*Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай  
хуулийн шинэчилсэн найруулгын төслийн  
тухай*

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч авах харилцааг Засгийн газрын 1994 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах журам”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 201 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын иргэн гадаадад хөдөлмөр эрхлэхэд нь зуучлах үйлчилгээ явуулах эрхийн зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зохицуулж ирсэн. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг анх 2001 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хурал баталснаар Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдний эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын үндсийг бүрдүүлсэн. Хуулийн зорилго, зохицуулалт, үйлчлэх хүрээ өнөөгийн улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл, шинээр бий болсон харилцааг зохицуулахад учир дутагдалтай байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төслийг Монгол Улсаас гадаад улсад, гадаад улсаас Монгол Улс руу чиглэсэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцаанд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шилжилт хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг үндэсний хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд тулгуурлан, нэгдмэл байдлаар зохицуулах зорилгоор 5 бүлэг, 41 зүйлтэй байхаар боловсрууллаа. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн төслийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээтэй хэрхэн уялдах, хэрэглэх эрэмбэ, баримтлах зарчмыг тусгасан.

Хоёрдугаар бүлэгт: Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхлэхээр тусгасан. Төрийн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичиг, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх асуудлыг нарийвчлан тодорхой заасан. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэдийг хохироохоос урьдчилан сэргийлэх, хохирол учруулсан тохиолдолд хохирлыг барагдуулах санхүүгийн чадавхтай байх шаардлагыг шинээр тогтоосон. Мөн гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийг эргэн суурьших боломжийг бүрдүүлэх дэмжлэгийг тодорхойлж, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа оролцоог тодорхойлсон. Гадаадад ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой учирч болох аливаа эрсдэлээс хамгаалах асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулахаар тусгасан.

Гуравдугаар бүлэгт: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэслэн хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах, зөв зохицуулах хүрээнд гадаадаас ажиллах хүч авах ажил олгогчид тавих шалгуурыг бий болгосон. Гадаадын иргэнийг авч ажиллуулах ажлын байранд дотоодын ажил хайгчаас ажиллах санал ирээгүй, сул хэвээр байгаа тохиолдолд тухайн ажил олгогч зохих журмын дагуу гаднаас ажиллах хүч авч ажиллуулдаг болохоор хуульчилсан. Мөн гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны ангилал, төрлөөс хамааруулан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, тоог тогтоох, гадаадын иргэнийг ажлын байранд сонгон авч ажиллуулах, сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлын байрны төлбөр тогтоох зохицуулалтыг бүхэлд нь шинэчлэв. Ингэхдээ Монгол Улсад дутагдалтай нарийн мэргэжлийн ажлын байранд гадаадын иргэнийг ажиллуулах, дотоодоос хангах боломжтой ажлын байранд гадаадаас ажилтан авахыг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлэх

зохицуулалтыг тусгасан.

Дөрөвдүгээр бүлэгт: Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний харилцаанд оролцогчдын үүрэг, хариуцлага, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдааг хангах, гадаад улсад хөдөлмөр эрхлэх Монгол Улсын иргэний болон Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэний мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бий болгов. Энэ нь ажил олгогч мэдээллийн сангаас ажилтнаа сонгох, албан бус зуучлалын үйл ажиллагааг таслан зогсоох, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж үзэв.

Тавдугаар бүлэгт: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн захиргааны болон хөндлөнгийн хяналт тавих, төрийн байгууллага харилцан мэдээлэл солилцох, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаарх зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй шинэ зохицуулалтыг тусгасан:

1. Ажил олгогч эхний ээлжинд дотоодоос ажилтан авч ажиллуулах шаардлагыг шинээр тусгасан. Ажил олгогч ажлын байрны захиалгаа мэдээллийн санд байршуулж, ажилтнаа идэвхтэй хайсан боловч ажлын байр сул хэвээр байгаа тохиолдолд гадаадаас ажилтан авах хүсэлт гаргах эрх үүсэхээр хуульчиллаа. Дотоодоос хангах боломжгүй ажлыг байранд гадаад ажилтан авах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл бүрдэнэ.

2. Гадаадаас ажилтан сонгох, ажилтан авах зөв гарцыг бий болгох, албан бус зуучлалыг зогсоох зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн санг бүрдүүлэх, ажил олгогч ажилтнаа мэдээллийн сангаас сонгох боломжийг шинээр тусгасан.

3. Одоо үйлчилж буй хууль тогтоомжоор гадаадын ажиллах хүчний хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгах давтамжийг тогтоосон зохицуулалтгүй байгааг бусад орны туршлагын дагуу хугацаа давтамжийг тогтоож, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох, зөвшөөрөл бүхий гадаадын иргэнийг өөр байгууллагад шилжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг шинээр бий болгов.

4. Олон Улсын хөдөлмөрийн байгууллага болон Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас гишүүн орнууддаа зориулсан үндсэн зөвлөмжийн дагуу хөдөлмөр, гадаад харилцаа, хууль зүй, эрүүл мэнд, боловсролын асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, мэдээлэл харилцан солилцох зохицуулалтыг тусгасан.

5. Гадаадаас ажилтан авахад орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага оролцоо хангалтгүй байсныг өөрчилж, оролцоог хангах, зарим чиг үүргийг орон нутагт шилжүүлж, тухайн үйл ажиллагаанд нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага тус тус хяналт тавьдаг байхаар томьёолсон.

6. Гадаадаас ажилтан авах хувь хэмжээ /квот/-ний тогтолцоог бүрэн өөрчилсөн. Одоогийн хуулиар хуулийн этгээдийн гадаад ажилтан авч хөдөлмөр эрхлүүлэх урьдчилсан зөвшөөрлийг Засгийн газар хэлэлцэн шийдвэрлэдэг байсныг салбарын яамдын саналыг үндэслэн гадаад ажилтны тоог жил бүр Засгийн газар тогтоохоор тусгалаа.

7. Ажлын байрны төлбөрийн доод хэмжээг хуулиар тогтоож, салбарын онцлогийг харгалзан Засгийн газар ялгаатай тогтоох боломжийг бүрдүүлсэн. Ингэхдээ Ашигт малтмалын тухай хуулиар ногдуулж, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутагт төлж буй гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулсны ажлын байрны

төлбөрийн асуудлыг хөндөөгүй.

8. Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх харилцааг нарийвчлан зохицуулав. Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн албадын тухай 181 дүгээр Конвенц” болон холбогдох бусад конвенцид нийцүүлэн зуучлалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тусгаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хариуцлагдажуулсан. Тусгай зөвшөөрлийг тухайн улсын эрх бүхий байгууллагатай гадаадад ажиллах хүч илгээх гэрээ байгуулсан, санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай хуулийн этгээдэд олгоно.

9. Зуучлуулагчийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх, учирсан хохирлыг бууруулах, барагдуулах асуудлыг шинээр тусгасан. Гадаадад ажиллаж буй иргэдээ эргэн суурьшихад дэмжих төсөл, хөтөлбөрт хамруулах зохицуулалтыг бий болгосон.

10. Зуучлалын хөлсний нийт хэмжээ нь зуучлуулагчийн зуучлагдах ажлын байрны нэг сарын хөдөлмөрийн хөлснөөс хэтрэхгүй байхаар тогтоож, зуучлалын зардлын дийлэнх хэсгийг ажил олгогч хариуцахаар зохицуулсан.

Хуулийн төслийг боловсруулахдаа Филиппин, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Вьетнам, Япон зэрэг улсын хууль тогтоомжийг судалж, дотоодын хууль тогтоомжтой уялдуулан тусгасан. Хуулийн төслийн үр дагаварт хийсэн үнэлгээ болон холбогдох судалгаа, зөвлөмж, дүгнэлтийг харгалзан үзсэн болно. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт эрдэмтэн, судлаач, холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан бөгөөд яамд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага болон иргэдээс санал авч тусгалаа. Хуулийн төслийг боловсруулан яамны цахим хуудсанд байршуулсан бөгөөд хуулийн төслийн хэлэлцүүлгийг 3 удаа хийсэн, мөн салбарын хэмжээний уулзалт зөвлөгөөний үед тухай бүр танилцуулж, оролцогчдын саналыг авч тусгасан.

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ